



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/132

Улаан-Уул

Цаг үеийн ажлыг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сумын Онцгой комиссийн хуралдааны 09 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг үеийн асуудлаар Сумын Онцгой комиссын хурлаас гарсан дараахь шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

1.1.Дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг доголдолгүй явуулж, инженерийн шугам сүлжээний бүх холболтыг шалгаж, шугам сүлжээнд тохируулга хийх, гэрээнд заагдсан техникийн үзүүлэлт бүхий зуух, тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор хийж дуусган, тайлан мэдээ ирүүлэхийг дулаан үйлдвэрлэгч "Скейл" ХХК-ны захирал Б.Мөнгөнтуулд,

1.2.Цэвэр бохир, дулааны худгуудын дулаалгыг шалгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Зоригт)-д

1.3.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй эрсдэлтэй байгаа тул малчин өрх, иргэдэд нэн шаардлагатай өвс тэжээл, хоол хүнсний талаарх судалгаа тооцоог гарган 2022 оны 10 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг багуудын Засаг дарга нарт

1.4. Сумын хэмжээний 0-5 насны хүүхэдтэй эхчүүд, жирэмсэн эхчүүд, ахмад настан, асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн гэрийн хаягийн байршил зүйн зургийг нэг бүрчлэн гаргаж, мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг Эрүүл мэндийн дарга (А.Сүхээ), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ө.Хашбилэг), багуудын Засаг дарга нарт

642201276



1.5.Сумын нийт иргэдийн утасны дугаарын судалгаа гарган, “Багц мессеж” үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2022 оны 10 дугаар сарын 30-ны дотор зохион байгуулахыг ХАА-н тасгийн дарга (О.Энхболд), Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Г.Баасанжаргал), Санхүү албаны дарга (С.Хонгорзул) нарт.

2.Гамшгаас хамгаалах хариу арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагдах хөрөнгийн нөөцийг Засаг даргын нөөц хөрөнгөд төсөвлөхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Зоригт), Санхүү албаны дарга (С.Хонгорзул) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ